



# ШҮҮХИЙН АХМАДУУДЫН ХОЛБООНЫ БҮСИЙН УУЛЗАЛТ-ТЭМЦЭЭНИЙ УДИРДАМЖ

холбооны Ажлын албаны дарга Б.Сарантуяа



Холбооны Удирдах зөвлөлийн  
2025 оны 05 дугаар сарын 21-ний  
өдрийн А/10 тоот тогтоолын  
нэгдүгээр хавсралтаар баталсан.

## Нэг:Зорилго

Монгол улсын Ерөнхийлөгчийн санаачлан хэрэгжүүлж буй “Эрүүл монгол хүн” үндэсний хөдөлгөөн, “Эерэг хандлага-Эрүүл нийгэм” аяныг идэвхжүүлэн холбооны гишүүдийн оролцоог дэмжих, эрүүл амьдралын хэв маягийг хэвшүүлэх, ёс зүй, соёл, харьцаа, хандлагыг дээшлүүлэх, спорт, биеийн тамирын арга хэмжээгээр дамжуулан гишүүдийн эв нэгдлийг бэхжүүлэх, амьдралын чанарыг дээшлүүлэх, нийгэмд үзүүлэх нөлөөллийг нэмэгдүүлэхэд **УУЛЗАЛТ-ТЭМЦЭЭНИЙ** зорилго оршино.

## Хоёр.Бүсийн тэмцээний төрөл

Бүсийн Уулзалт-тэмцээний үеэр зохиогдох спортын тэмцээний төрөл, шагнал урамшлийн хэмжээг санхүүгийн боломж нөхцөлөө тооцож өөрсдөө тогтооно.

## **Гурав. Бүсийн тэмцээн зохион байгуулах хугацаа**

Бүсийн тэмцээнийг жил бүрийн 6 дугаар сарын 15-ны дотор шүүхийн Тамгын газар, Ахмадын салбар зөвлөл хамтран зохион байгуулна.

Бүсийн тэмцээнийг тухайн бүсэд хамрагдаж буй шүүхийн Тамгын газар, Салбар зөвлөлүүд жил бүр ээлжлэн удирдан зохион байгуулна.

## Дөрөв. Шагнал урамшуулал

1. Бүсийн тэмцээний үйл ажиллагаа, шагналын зардлыг Засгийн газрын 2024 оны 243 дугаар тогтоолоор батлагдсан “Ахмадын сан байгуулан ажиллуулах журам”-ын 3.1.8-д заасан Ахмадуудын дунд идэвхитэй насжилтыг дэмжих, амралт, аялал, урлаг, спортын арга хэмжээ, уралдаан тэмцээн зохион байгуулахад дэмжлэг үзүүлнэ гэснийг үндэслэн харьяа шүүхүүдийн Тамгын газрын дэргэдэх “Шүүхийн ахмадын сан”-гаас санхүүжүүлнэ.

2. Холбооны Хуримтлалын сангаас Бүсийн тэмцээний үйл ажиллагаанд 1.000.000 төгрөгийн дэмжлэг үзүүлнэ.

## **Тав. Тавигдах шаардлага**

1.Тэмцээнд оролцогч гишүүд нь Холбооны гишүүнчлэлийн үнэмлэхтэй байна.

## Зургаа.“БҮС”- ийн бүтэц зохион байгуулалт

Шүүхийн Ахмадын салбар зөвлөлүүдийг Төвийн бүс, Хангайн бүс, Баруун бүс, Зүүн бүс, Говийн бүс, Нийслэлийн бүс гэж газар нутгийн байршлыг харгалзан 6 бүс болгож тогтооно.

## 6. Нийслэлийн бүс

- Нийслэлийн ЭХДЗШ-ны шүүхийн АСЗ, гишүүдийн тоо-27
  - Нийслэлийн ИХДЗШ-ны шүүхийн АСЗ, гишүүдийн тоо-22
  - Захиргааны хэргийн ДЗШ-ны шүүхийн АСЗ, гишүүдийн тоо-5
  - Нийслэл дэх Захиргааны хэргийн АШ-ны шүүхийн АСЗ, гишүүдийн тоо-7
  - БЗД, СБД, ЧД-ийн ЭХАШ-ны шүүхийн АСЗ, гишүүдийн тоо-13
  - БЗД, СБД, ЧД-ийн ИХАШ-ны шүүхийн АСЗ, гишүүдийн тоо-31
  - БГД, СХД, ХУД-ийн ЭХАШ-ны шүүхийн АСЗ, гишүүдийн тоо-20
  - БГД, ХУД, СХД-ийн ИХАШ-ны шүүхийн АСЗ, гишүүдийн тоо-20
  - Налайх, Багахангай дүүргийн шүүхийн АСЗ, гишүүдийн тоо-13
  - Багануур дүүргийн шүүхийн АСЗ, гишүүдийн тоо-5
  - Төв аймаг дахь шүүхийн АСЗ, гишүүдийн тоо-29
- Бүсийн гишүүдийн нийт тоо-192  
Нийт 465 гишүүн хамрагдана.

### **1.Төвийн бүс:**

- Архангай аймаг дахь шүүхийн АСЗ. гишүүдийн тоо-9,
- Баянхонгор аймаг дахь шүүхийн АСЗ. гишүүдийн тоо-14,
- Өвөрхангай аймаг дахь шүүхүүдийн АСЗ /Хархорин суман дахь Сум дундын шүүх/, гишүүдийн тоо - 13,
- Хөвсгөл аймаг дахь шүүхийн АСЗ, гишүүдийн тоо-16,

Бүсийн гишүүдийн нийт тоо-52

## **2.Хангайн бүс:**

- Дархан-Уул аймаг дахь шүүхийн АСЗ, гишүүдийн тоо-22,
  - Булган аймаг дахь шүүхийн АСЗ, гишүүдийн тоо-12
  - Сэлэнгэ аймаг дахь шүүхүүдийн АСЗ /Мандал, Сайхан суман дахь Сум дундын шүүх/, гишүүдийн тоо-24,
  - Орхон аймаг дахь шүүхийн АСЗ, гишүүдийн тоо-8
- Бүсийн гишүүдийн нийт тоо-66

### 3.Баруун бүс:

- Баян-Өлгий аймаг дахь шүүхийн АСЗ гишүүдийн тоо-8,
- Ховд аймаг дахь шүүхүүдийн АСЗ /Ховд аймгийн Булган суман дахь Сум дундын шүүх/, гишүүдийн тоо-22,
- Увс аймаг дахь шүүхийн АСЗ, гишүүдийн тоо-13,
- Завхан аймаг дахь шүүхийн АСЗ, гишүүдийн тоо-10,
- Говь-Алтай аймаг дахь шүүхийн АСЗ, гишүүдийн тоо-9,  
Бүсийн гишүүдийн нийт тоо-62

#### **4.3үүн бүс:**

- Хэнтий аймаг дахь шүүхийн АСЗ /Бор-Өндөр дахь Сум дундын шүүх/, гишүүдийн тоо-18,
- Сүхбаатар аймаг дахь шүүхийн АСЗ, гишүүдийн тоо-18,
- Дорнод аймаг дахь шүүхийн АСЗ, гишүүдийн тоо-16,  
Бүсийн гишүүдийн нийт тоо-59

## 5.Говийн бүс:

- Өмнөговь аймаг дахь шүүхийн АСЗ, гишүүдийн тоо-11,
- Дорноговь аймаг дахь шүүхийн АСЗ/ Замын-Үүд дэх Сум дундын шүүх/, гишүүдийн тоо-15,
- Дундговь аймаг дахь шүүхийн АСЗ, гишүүдийн тоо-8,
- Говьсүмбэр аймаг дахь шүүхийн АСЗ, гишүүдийн тоо-7,

Бүсийн гишүүдийн нийт тоо-63